

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 5 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Б.Болор**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2015 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо уг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хийж, дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулж танилцуулахаар шийдвэрлэлээ.

Төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн дагуу хэрэгжих зургаан төслийн хүрээнд импортоор оруулж байгаа материал гэсэн нэрийн доор гаднаас төсөлд хамааралгүй бараа материалыг оруулж ирэх, татвараас зайлсхийх нөхцөл үүсгэхгүй байх тал дээр анхаарах нь зүйтэй гэсэн санал гаргасан.


Уг хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Б.Болор уг хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр батлуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Б.БОЛОР**